



БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛС БА
ЗӨВЛӨЛТ СОЦИАЛИСТ БҮГД НАЙРАМДАХ
ХОЛБООТ УЛСЫН ХООРОНД 1971- 1975
ОНД ХАРИЛЦАН БАРАА НИЙЛҮҮЛЭХ ТУХАЙ
ХЭЛЭЛЦЭЭР

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар ба
Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын Засгийн
газар,

тус хоёр орон болон бүх социалист нөхөрлөлийн ор-
ны эрх ашигт эдийн засгийн харилцааг цэашид хөгжүүлэхийг
эрмэлзэн,

олон улсын хөдөлмөрийн социалист хуваарийн зарчмыг
үндэслэн түүний давуу талыг харгалзаж,

Бүгд Найрамдах Монгол Ард Улс ба Зөвлөлт Холбоот
Улсын улс ардын аж ахуйн төлөвлөгөөг амжилттай биелүү-
лэхэд харилцан бараа нийлүүлэх тухай удаан жилийн Хэлэл-
цээрүүд нь их ач холбогдолтой болохыг тэмдэглэж,

Бүгд Найрамдах Монгол Ард Улс ба Зөвлөлт Социалист
Бүгд Найрамдах Холбоот Улсын хооронд 1966 оны I-р сарын
15-нд байгуулсан найрамдал, хамтын ажиллагаа ба харилцан
туслалцах тухай Гэрээ, Бүгд Найрамдах Монгол Ард Улс ба
Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын хооронд
1957 оны 12-р сарын 17-ны өдөр байгуулсан Худалдааны
гэрээг удирдлага болгон,

1965 оны 8-р сарын 4-нд гарын үсэг зурсан Бүгд Най-
рамдах Монгол Ард Улс ба Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах
Холбоот Улсын хооронд 1966-1970 онд харилцан бараа нийлүү-
лэх тухай Хэлэлцээр амжилттай биелэгдэж хүчин төгөлдөр
байх хугацаа энэ онд дуусч байгааг анхаарч,

харилцан бараа нийлүүлэх тухай удсан жилийн шинэ
Хэлэлцээрийг таван жилийн хугацаагаар байгуулахаар шийд-
вэрлэн доор дурдсан зүйлийн талаар харилцан тохиролцов.

Нэгдүгээр зүйл

Бүгд Найрамдах Монгол Ард Улсаас Зөвлөлт Социалист

Бүгд Найрамдах Холбоот Улсад, Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсаас Бүгд Найрамдах Монгол Ард Улсад 1971 оны I-р сарын I-нээс 1975 оны 12-р сарын 31-нийг дуустал хугацаанд харилцан нийлүүлэх барааг тус Хэлэлцээрт хавсрагдсан I ба 2-р жагсаалтуудыг үндэслэн гүйцэтгэнэ.

Хоёр этгээд нь бараа нийлүүлэх дараагийн жил эхлэхийн өмнө харилцан бараа нийлүүлэх тухай жил бүрийн протоколыг байгуулах үед эдгээр жагсаалтанд тодотгол ба нэмэлт хийх байх болно. Энэ жагсаалтууд хэлэлцээрийн салгуу хэсэг болно.

Хоёр этгээд нь бараа гүйлгээний хэмжээг нэмэгдүүлэх, түүнчилэн энэхүү Хэлэлцээрт заасан барааны нэр төрлийг олшруулах талаар хүч чармайлт тавих болно.

Хоёрдугаар зүйл

Монголын нийлүүлэх барааны өртгөөс давах зөвлөлтийн нийлүүлэх барааны өртгийн илүүдлийг төлөхийн тулд 1970 оны 12-р сарын 28-ны өдрийн Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар ба Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын Засгийн газрын хооронд 1971-1975 онд эдийн засгийн талаар хамтран ажиллах тухай Хэлэлцээрийн дагуу Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын Засгийн газраас Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газарт олгосон зээлийн хэсэг болох 200 сая. рублийг энэхүү Хэлэлцээрээр зөвлөлтийн үүргийн өртгийг тодорхойлохдоо бодолцов.

Дурдсан зээлийн хөрөнгийг жил бүр 40 сая рублиар тэнцүү хэмжээгээр ашиглах болно. Хоёр этгээд нь жил бүрийн протоколоор энэ хөрөнгийг тодруулж болно.

1970 оны 12-р сарын 28-ны өдрийн Хэлэлцээрт заасан 1971-1975 онд Бүгд Найрамдах Монгол Ард Улсаас Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсад төлбөл зохих төлбөрийг энэхүү Хэлэлцээрээр монголын үүргийн /барааны/ өртгийг тодорхойлохдоо бодолцов.

Гуравдугаар зүйл

Нэг талаас монголын гадаад худалдааны байгууллагууд нөгөө талаас зөвлөлтийн гадаад худалдааны байгууллагууд энэхүү Хэлэлцээрт заасан барааг нийлүүлэхээр хоорондоо

гэрээ байгуулах бөгөөд түүний дотор удаан хугацааны гэрээг байгуулж болно.

Эдгээр гэрээнд барааны нэр төрөл, тоо хэмжээ, /спецификация/, үнэ, нийлүүлэх хугацаа зэрэг бусад нөхцөлийг заана. Хэрэв Хэлэлцээр хүчин төгөлдөр байхад дараа жилийн I-р сарын I-ний байдлаар зарим барааны нийлүүлэх хугацаа дээрх гэрээнүүдэд заагдсанаас хожимдвол дутууг тэр жилийн 4-р сарын I-ний дотор нийлүүлэх болно.

Дөрөвдүгээр зүйл

Энэхүү Хэлэлцээрийн дагуу монголын ба зөвлөлтийн гадаад худалдааны байгууллагуудын хооронд байгуулагдсан бараа нийлүүлэх гэрээ ёсоор нийлүүлэгдэх бүх бараанд "ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудын бараа нийлүүлэх ерөнхий нөхцөлийг /ЭЗХТЗ-ийн 1968 оны БНЕН/" баримтлах болно.

Тавдугаар зүйл

Энэхүү Хэлэлцээрийн хүрээнд нийлүүлэх барааны үнийг шилжих рублиэр, зохих барааны дэлхийн гол зах зээлийн үнийг капиталист зах зээлийн хорт нөлөөллөөс цэвэрлэсний үндсэн дээр, Эдийн Засгийн Харилцан Туслах Зөвлөлийн гишүүн орнуудын хоорондын худалдааны гэрээний үнэ тогтоох тухай Эдийн Засгийн Харилцан Туслах Зөвлөлийн байгууллагуудын тогтоосон, одоо мөрдөж байгаа зарчим, шийдвэр зөвлөмжүүдийн үндсэн дээр тогтоох болно.

Зургадугаар зүйл

Энэхүү Хэлэлцээрээр нийлүүлэх барааны төлбөр, мөн дээр дурдсан зээлийн хэсэг 200 сая рублийг олгох, Хэлэлцээр ёсоор БНМАУ-д олгосон зээлийн хүүгийн ээлжит төлбөр, түүнчилэн бараа гүйлгээтэй холбогдох ба худалдааны бус (82-63) төлбөрийн тооцооны тухай хэлэлцээрт хамаарагдахгүй төлбөрүүдийг шилжих рублиэр, БНМАУ-ын Банк ба ЗСБНХУ-ын гадаад худалдааны Банк нь Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Олон Улсын Банкнд байгаа тус тусын харилцах дансаар дамжуулан, шилжих рублиэр олон талын тооцоог хийх ба Эдийн засгийн хамтын ажиллагааны Олон

Улсын Банкныг байгуулах тухай 1963 оны 10-р сарын 22-ны
Хэлэлцээрийн дотуу гүйцэтгэл.

Аолдугаар зүйл

Хоёр засгийн газрыг төлөөлөгсөд нь аль нэг этгээ-
дийн санал тавьснаар энэхүү Хэлэлцээрийг хэрхэн биелүүлж
байгаа явцыг хэлэлцэн, шаардагдвал зохих зөвлөмж боловс-
руулахаар Улаанбаатар буюу Москва хотод ээлжлэн уулзж
байна.

Наймдугаар зүйл

БНМАУ-ын Улсын Банк ба ЗСБНХУ-ын гадаад худалдааны
Банк энэхүү Хэлэлцээрийн хүчин төгөлдөр байх хугацаа
дууссаны дараа, энэхүү Хэлэлцээрийг үндэслэн байгуулсан
гэрээ ба түүний хүчин төгөлдөр байх хугацаа дуусч бай-
гаа үед биелэгдээгүй байсан бүх гэрээтэй холбогдсон
төлбөрийн бичиг баримтыг хүлээн авч байх болно.



Хэрэв аль нэг этгээд нь энэхүү Хэлэлцээр ёсоор
бараа нийлүүлэх зохих үүргээ бүрэн биелүүлээгүй бол
тэр этгээд нь энэхүү Хэлэлцээрийн хүчин төгөлдөр байх
хугацаа дууссан өдрөөс эхлэн 6 сарын дотор уул үүргийг
биелүүлэхэд шаардагдах арга хэмжээг авна.

Есдүгээр зүйл

Энэ Хэлэлцээр нь гарын үсэг зурсан өдрөөс эхлэн
хүчин төгөлдөр болох ба 1975 оны 12-р сарын 31-нийг дуус-
тал хүчинтэй байна. Хэлэлцээрийг 1970 оны 12-р сарын 30-
ны өдөр Москва хотноо монгол, орос хэл дээр хоёр эх хувь
үйлдсэн бөгөөд дурдсан хувиуд нэгэн адил хүчинтэй байна.

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ
АРД УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫН ЭРХ ОЛГОСНООР

ЗӨВЛӨЛТ СОШИАЛИСТ БҮГД
НАЙРАМДАХ ХОЛБООТ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН ЭРХ
ОЛГОСНООР



ЗУУЦ.

1970 оны 12-р сарын
30-ны өдрийн Хөлөл-
цөөрийн хавсралт

ЗСБНХУ-ААС БНМАУ-Д 1971-1975
ОНД НИЙЛҮҮЛЭХ БАРААНЫ
ЖАГСААЛТ I

БНИК-ийн дугаар	БАРААНЫ НЭР	Хэмжих нэгж	1971 ОН	1972 ОН	1973 ОН	1974 ОН	1975 ОН
I00	Төмрийн суурь машин	ширхэг	62	40	40	40	40
I01-I03	Дархны суурь машин	мян.руб.	20	20	20	20	20
II0	Эрчим хүчний төхөөрөмж	"	1535	1600	1650	1650	1700
үүнээс:							
II016	нүүдлийн цахил- гаан станц	ширхэг	203	260	280	290	300
II098	эрчим хүчний төхөөрөмжийн сэлбэг	мян.руб.	290	650	700	750	800
III	Цахилгаан техни- кийн төхөөрөмж	"	715	875	900	925	950
үүнээс:							
III01-02	цахилгаан хө- дөлгүүр	ширхэг	710	1000	1000	1000	1000
III28	гагнуурын төхөө- рөмж	мян.руб.	25	40	50	70	95
III29	хүчний транс- форматор	ширхэг	106	120	120	120	120
II3	Кабель ба утас	мян.руб.	650	750	850	900	1000
үүнээс:							
II301	хуягласан кабель	км.	70	75	75	80	80
II302	хүчний кабель	км.	60	70	80	90	100
II303	шланган ба өрөмд- лөгийн кабель	км.	150	150	160	160	170
II320	бүрээсгүй утас	тонн	400	400	400	400	400



БНХ-ийн дугаар	Барааны нэр	Хэмжээ нэгж	1971 он	1972 он	1973 он	1974 он	1975 он
II325	техөөрөмжийн утас	км	600	600	600	600	600
II33I	гэрлийн утас	"	I350	I400	I400	I400	I400
I20	Ашигт малтмалыг ил ба далд аргаар олз- ворлох үйлдвэрийн техөөрөмж	мян.руб.	295	290	300	3I0	320
I2I	Бутлах тээрэмдэх техөөрөмж	мян.руб.	80	I00	I00	I00	I00
I2834	Шатхуун агуулах сав	"	I40	I50	I75	200	200
I3	Өргөх-тээвэрлэх техөөрөмж	"	600	620	640	650	700
	үүнээс:						
I3007	автокран	ширхэг	I0	II	I2	I3	I4
I30I0	цамхагт кран	"	-	2	2	2	2
I33080I- I330804	конвейр ба транс- портер	"	29	30	30	30	30
I3309	авто ачигч	"	II	I4	I7	20	22
I4	Хөнгөн ба хүнсний үйлдвэрийн техөөрөмж	мян.руб.	200	350	450	500	500
I5I0I	Хөрөө рам	ширхэг	7	I0	I0	I0	I0
I52	Модны суурь машин /ширээнийх оролцох- гүй/	"	II	25	40	50	50
I53	Барилгын материалын үйлдвэрийн техөөрөмж	мян.руб.	I50	I50	I50	I50	I50
	үүнээс:						
I53050I	бетон зуурагч	ширхэг	II	20	20	20	20
I540I	экскаватор	"	I8	20	20	20	20
I5407	автогрейдер	"	2	2	2	2	2
I5408	бульдозор	"	I8	20	20	2I	2I
I5409	скрепер	"	-	2	2	3	3
I55	Насос-компрессорын техөөрөмж	мян.руб.	420	320	320	320	320
	үүнээс:						
I550I	насос	ширхэг	790	5I0	5I0	5I0	5I0
I5502	компрессор	"	I5	20	20	20	20
I56	Нийгэм ахуй ба гал эсэргүүцэх техөөрөмж	мян.руб.	480	500	600	700	800
	үүнээс:						
	халаалтын радиатор	мян.эжм	65	70	75	75	80
I57	Хэвлэх үйлдвэрийн техөөрөмж	мян.руб.	I60	I40	I40	I40	I40



БНХ-ийн дугаар	Барааны нэр	хэмжих нэгж	1971 он	1972 он	1973 он	1974 он	1975 он
I58	холбооны төхөөрөмж	мян.руб.	230	300	300	300	300
I5970	Кино төхөөрөмж	"	180	200	200	200	200
I70-I71	Лабораторын ба						
I78-I79	хэмжих төхөөрөмж	"	505	700	700	700	700
I72	Эмнэлгийн төхөөрөмж ба багаж	"	245	300	300	300	300
I7301	Холхивч	мян.шир.	71	100	100	100	100
I8002-03	Трактор	ширхэг	404	600	600	600	600
I8098	Тракторын сэлбэг	мян.руб.	850	1600	1700	1800	1900
I81	Хөдөө аж ахуйн машин	"	2700	3500	3500	3500	3500
	үүнээс:						
I811101	үр суулгагч	ширхэг	160	210	210	210	215
I811601	үр тарианы комбайн	"	120	180	180	190	190
I812201	тракторын хөдөгч	"	100	240	240	300	300
I8198	хөдөө аж ахуйн машины сэлбэг	мян.руб.	1150	1200	1200	1200	1200
I9015	Ачааны битүү вагон	ширхэг	30	12	12	12	12
I9021	Хагас вагон	"	20	20	20	20	20
I9024	Суудлын вагон	"	5	8	8	8	8
I9098	Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний сэлбэг	мян.руб.	240	300	350	400	450
I9101	Ачааны автомашин	ширхэг	381	460	480	500	500
I9103	Автобус	"	50	50	50	50	50
I9112	Автотракторын чиргүүл	"	544	600	600	600	600
I9116	Гаражийн төхөөрөмж	мян.руб.	107	120	150	170	170
I9117	Тусгай машин	ширхэг	203	190	190	190	190
I9198598	Автын сэлбэг	мян.руб.	4000	4400	4700	4900	5000
I980103	Нисэх онгоц АН-24В	ширхэг	1	1	1	1	1
I9806	Нисэх онгоцны сэлбэг ба онгоцны төхөөрөмж	сая.руб.	1,1	1,2	1,3	1,4	1,5
I9501	Суудлын машин	ширхэг	182	170	170	180	180
I9510	Мотоцикл	"	200	2000	2000	2000	2000
22001	Нисэх онгоцны бензин	мян.тн.	7,3	7	7	7	7

БННХ-ийн дугаар	Бэрэвн нэр	хэмжих нэгж	1971 он	1972 он	1973 он	1974 он	1975 он
22003	Авто бензин	"	131	145	150	155	160
22302	Нисэх онгоцны түлш	"	6,5	5,5	5,5	5,5	5,5
22401	Дизелийн түлш	"	82	100	105	110	110
22502	Түлшний мазут	"	7	7	7	7	7
226-227	Тос ба тослох материал	"	12	14,7	15	15,5	16
22901	Битум	"	3,4	3,4	3,6	3,8	4
26001	Ширэм	"	1	1,2	1,2	1,2	1,2
264	Хар төмөрлөгийн цувимал	"	12	12,5	13	14	14
26501	Цайрдсан гөлмөн төмөр	тонн	550	600	650	700	700
26505	Калиброван ган	"	650	700	750	800	800
26601- 07	Ган хоолой	мян.тн.	3,5	3,2	3,4	3,7	4
26802	Ердийн төмөр утас	тонн	2000	1750	1750	1750	1750
26807	Хадаас	"	1200	1200	1200	1300	1400
26813	Ган татлага	"	170	180	180	180	180
30	Химийн бүтээгдэхүү- нүүд	мян.руб.	1160	900	900	900	900
үүнээс:							
3000101	хүхрийн хүчил	тонн	930	1100	1100	1100	1100
30107	хүхэрт натрий	"	450	450	450	500	530
30258	натрит хромпик	"	480	480	500	560	600
30312	креолин	"	1200	1100	1100	1100	1100
30606	канифоль	"	100	200	200	200	200
30924	карбид кальци	"	180	80	80	80	80
31	Арьсны ба лак будаг, идээлэх материал	мян.руб.	420	450	500	500	500
үүнээс:							
31001	арьсны будаг	тонн	50	70	70	70	70
3111404	тосон цагаан будаг	"	150	160	160	160	160
3111599	тосон будаг	"	600	600	600	600	600
33101	Киноны хальс	мян.м.	2000	2500	2500	2500	2500
34005	Суперфосфат	тонн	-	2200	2700	3300	3800
34802	Гранозан	"	-	200	200	200	200
3480302	Гексахлоран дуст	"	860	1000	1000	1100	1100



5.

БНМА-ийн дугаар	БАРЛААН НЭР	ХЭМЖИХ НЭГЖ	1971 -ОН	1972 -ОН	1973 -ОН	1974 -ОН	1975 -ОН
55110	Автомашинны дугуй хөймрэн хамт	мян.шир.	29	30	30	30	30
40001	Цемент	мян.тн	20	20	20	20	21
40101	Цонхны шил	мян.кв.м	100	250	250	250	250
40201-02	Дээврийн хар цаас	"	400	1200	1200	1200	1200
40301	Өнгөлгөөний шаазан хавтан	"	30	30	30	30	30
40302	Шалны шаазан хавтан	"	30	30	30	30	30
50201	Чанер	куб.м.	700	700	700	700	700
50601	Сонины цаас	мян.тн.	2,6	2,6	2,6	2,6	2,6
50606	Хөвлэлийн цаас	"	1,6	1,8	1,8	1,8	1,8
50607	Гүн хөвлэлийн цаас	"	180	200	200	200	200
50619	Бичгийн цаас	"	0,6	0,9	0,9	0,9	0,9
55	Үр тариа ба суулгах материал	мян.руб.	300	400	400	400	400
57102	Архс ширний тос	тонн	100	110	120	130	140
57302	Олиф	"	650	800	800	800	800
59202	Олс	"	670	900	950	1000	1000
5920802	Шуудайн таар	мян.м.	3000	3000	3000	3000	3000
59216	Берзент	"	1200	1350	1450	1450	1550
59219	Боодлын льноджутон эд	"	885	1000	1000	1000	1100
60103	Сайн үүлтрийн бод мал	толгой	165	400	400	400	400
60104	Сайн үүлтрийн бог мал	"	170	300	300	300	300
7210404	Ногоон цай	тонн	3500	3700	4000	4500	4500
72303	Патока	"	1000	1130	1240	1340	1440
72901	Талхны хөрөнгө	"	76	80	80	80	80
80006	Махан консерв	мян.жиш.	800	800	800	-	-
8020201	Өтгөрүүлсэн сүү	"	2000	2000	2000	2000	2000
8020203	Хуурай сүү	тонн	445	520	540	570	600
82001	Улаан буудайн гурил	мян.тн.	15	15	15	15	15
8200306	Шар будаа	"	3,5	4	4	4	4

БННХ-ийн дугаар	Барээны нэр	Хэмжих нэгж	1971 он	1972 он	1973 он	1974 он	1975 он
8200307	Цагаан будаа	мян.тн.	5	7	7	7	8
83004	Ногооны консерв	мян.жм.					
83210	Шинэ жимс	тонн	400	400	400	400	400
833	Хатаасан жимс	"	150	200	200	200	200
84001	Сөхөр	мян.тн.	390	400	400	400	400
84109	Наран цэцгийн тос	тонн	17,6	20	22	23	24
8510104	Дунсан тэмхи	"	500	800	840	860	880
900	Хөвөн бүс бараа	"	500	1200	1200	1200	1200
901	Ноосон даавуу	сая.м.	39	40	40	42	45
902	Торго	мян.м.	200	200	200	200	200
9050201	Хувцасны хөвөн	сая.м.	3,3	4,1	4,3	4,5	4,5
914	Сүлжмэл эдлэл	тонн	800	1500	1500	1500	1500
930	Савхин гутал	мян.руб.	900	850	850	870	880
950021	Төмөр ор	мян.хос	220	270	270	200	200
960-962	Эмийн зүйл	мян.шир.	65	65	65	65	65
97005	Гэр ахуйн хөргүүл	мян.руб.	1400	2000	2000	2100	2100
97015	Радио хүлээн авагч ^{х/}	ширхэг	200	500	500	500	500
	үүнээс:	мян.шир.	39,5	40	40	40	40
9701502	транзисторт ра- дио хүлээн авагч	"	33,5	34	34	34	34
97034	Гэр ахуйн угсралгын машин	ширхэг	2000	1100	1100	1100	1100
9730101	Сургуулийн дэвтэр	сая.шир.	15	17	18	19	21
98905	Ширээний хулдаас	мян.м.	295	350	350	350	350
98906	Лаа	тонн	1600	1800	1800	1800	1800
98908	Шүдэнэ	мян. сая.м.	30	40	40	40	40

Харилцан бараа нийлүүлэх хилийн Протоколыг байгуулахдаа Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсаас Бүгд Найрамдах Монгол Ард Улсад автомашины аккумулятор нийлүүлэх, шатхуун цэнэглэгч, нисэх онгоцны түлш, патока зэргийн нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, мөн автомашины эдэлгээ сайтай дугуйг нийлүүлэх асуудлыг энэхүү хөгсөөлөлд заасан тоо хэмжээгээр нийлүүлэх бололцоог талууд нь хэрхэвч үзэх болно.

х/ тодорхой нэр төрлийг хич тохирно.

М.Пер.



НУУЦ.

1970 оны 12 дугаар сарын 30
ны өдрийн Хэлэлцээрийн
х а в с р а л т

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСААС ЗӨВЛӨЛТ
СОЦИАЛИСТ БҮГД НАЙРАМДАХ ХОЛБООТ
УЛСАД 1971-1975 ОНД НИЙЛҮҮЛЭХ БАРААНЫ
Х А Г С А А Л Т 2

БННХ-ийн дугаар	Барааны нэр	хэмжих нэгж	1971 - он	1972 - он	1973 он	1974 - он	1975 - он
24204	Тугалганы концентрат 40%	тонн	-	-	350	600	650
24205	Гурвалсан эсэл нь 60%-иас доошгүй вольфрамын концен- трат ^х)	тонн	180	120	270	370	400
24205	Гурвалсан эсэл нь 20%-иас доошгүй вольфрамын концен- трат ^х)	тонн	140	140	120	120	120
25005	Хайлуур жонш /I-3-р зэрэг/ ^х)	мян.тонн	35	35	35	45	60
26201	Хуучин төмөр	мян.тонн	15	15	15	15	15
500	Гуалин мод	мян.куб.метр	35	40	70	100	120
5110302	Ямааны ноолуур	тонн	750	750	760	760	780
5110401	Хонины халуун угаалгын ноос ^{хх})	тонн	5600	5800	6100	6500	7000
5110402	Ямааны ноос /ердийн/	тонн	600	600	600	600	600
5110403	Тэмээний ноос /ердийн/	тонн	2100	2100	2100	2100	2100
5110406	Ахар хурганы ноос /ердийн / ^{хх})	тонн	1700	1750	1750	1750	1750



51105	Бодын хөөвөр	тонн	350	350	350	350	350
52065	Тарваганы арьс	мян.шир	500	500	500	500	500
5810202	Шевро	мян.шир	150	150	150	150	150
58199	Шеврет	мян.шир	50	50	50	50	50
59002	Адууны хялгас	тонн	600	600	600	600	600
5900302	Сариагийн хялгас	тонн	150	150	150	150	150
5900901, 5900903	Хонь ямааны өлөн гэдэс	мян.гогцоо	750	800	1200	1200	1300
59014	Зэдэмцэр	тонн	1400	1400	1400	1400	1400
71001- 71002, 80001	Мах ба махны мөл /амьдмн жингээр/ үүнээс	мян.тонн	75	90	100	110	125
71001- 71002	Махны мөл/нядлагчаны/ /амьдмн жингээр/	мян.тонн	47	50	55	65	68
71004	Махны адуу	мян.толгой	60	60	60	60	60
901	Ноосон даавуу	мян.метр	280	280	280	280	280
90401	Хивс ба хивсэн эдлэл	мян.кв.метр	-	40	60	100	130
91101, 923	Савхин эдлэл /пальто,бээлий бусад савхин эдлэл/	мян.рубль	200	200	200	200	200
91103	Савхин цамц	мян.шир	65	70	75	80	90
912	Нэхий дээл	мян.шир	-	20	40	50	50
91907	Ноосон хөнжил	мян.шир	70	75	75	75	75
..	Бусад бараа	сая рубль	4	4	5	5	5

х/ ЗХУ-ын тусламжаар үйлдвэрийг өргөтгөх болон бусад арга хэмжээ авах үндсэн дээр монголын тал 1971-1975 онд ЗХУ-д нийлүүлэх эдгээр барааг нэмэгдүүлэх арга хэмжээ авах болно.

хх/ БНМАУ ба ЭСБНХУ-ын хооронд 1971-1975 оны улс ардын аж ахуйн төлөвлөгөөг зохицуулсан Протоколын дагуу монголын тал Зөвлөлт Холбоот Улсад нийлүүлэх эдгээр барааны хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээ авах болно(1971-1975 онд).

О.

М.Б.С.